

Golomt Capital[®]

ДЭЛХИЙН

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО
ХОНОГИЙН ТОЙМ**

2025.05.19

Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

ТОВЧ

- Дэлхийн хамгийн том хоёр эдийн засаг 90 хоногийн хугацаанд шинэчилсэн тарифуудын ихэнхийг түр зогсоохоор тохиролцсон бөгөөд энэ хугацаанд нэмэлт хэлэлцээрүүд үргэлжилнэ.
- Тус тайланд дурдсанаар, дөрөвдүгээр сарын хэрэглээний үнийн индекс (CPI) жилийн үзүүлэлтээр 2.3%-иар өссөн нь таамагласан 2.4%-иас доогуур, 2021 оноос хойших хамгийн удаан өсөлт болжээ.
- Дөрөвдүгээр сарын жижиглэн худалдааны өсөлт ердөө 0.1% байсан нь гуравдугаар сарын 1.7%-ийн өсөлтөөс эрс бага үзүүлэлт боллоо.
- АНУ-Хятадын хэлэлцээ гурван сарын хугацаанд үргэлжлэх болсонтой холбогдуулан Засгийн газраас ирэх боломжит дэмжлэгүүдийн талаарх хүлээлт түр хугацаанд саармагжиж байна.




S&P 500 индексийн 2025 оны таамаглал

Deutsche Bank	7,000
Société Générale	6,750
BMO Capital Markets	6,700
Bank of America	6,666
Barclays	6,600
RBC Capital Markets	6,600
Wells Fargo	6,500
Citigroup	6,500
Goldman Sachs	6,500
Morgan Stanley	6,500
JPMorgan Chase	6,500
UBS	6,400
Дундаж	6,678

Golomt_Capital published on TradingView.com, May 18, 2025 23:37 UTC-4

S&P 500 E-mini Futures · 1M · CME O5,617.50 H5,977.50 L5,596.00 C5,917.75 +298.50 (+5.31%) -30.75 (-0.52%)





АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2025.05.12-05.18

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ХҮЧТЭЙ СЭРГЭЛЭЭ

АНУ-ын хөрөнгийн индексүүд өнгөрсөн долоо хоногт эрчтэй өслөө. Гол шалтгаан нь өнгөрөгч амралтын өдрүүдэд Швейцарьт болсон хэлэлцээрийн дараа АНУ болон Хятад худалдааны зөрчлөө бууруулахаар тохиролцсон явдал байв. Nasdaq Composite индекс 7.15%-иар өсч, голлох индексүүдийн тэргүүнд бичигдсэн бол S&P 500 индекс 5.27%, Dow Jones Industrial Average 3.41%-ийн өсөлт үзүүлээ. Мөн S&P MidCap 400 болон Russell 2000 индексүүд зургаан долоо хоног дараалан өсчээ.

Дэлхийн хамгийн том хоёр эдийн засаг 90 хоногийн хугацаанд шинэчилсэн тарифуудын ихэнхийг түр зогсоохоор тохиролцсон бөгөөд энэ хугацаанд нэмэлт хэлэлцээрүүд үргэлжилнэ. Үүний хүрээнд АНУ-ын Хятадын бараанд ногдуулсан гаалийн тариф дунджаар 145%-иас 30% болж буурах бол Хятадын АНУ-ын бараанд ногдуулсан тариф 125%-иас 10% болж буурахаар боллоо. Мөн Саудын Араб АНУ-ын компаниудаас хиймэл оюуны өндөр хүчин чадалтай чип их хэмжээгээр худалдан авах тухай гэрээ ч зах зээлийн эерэг үүр амьсгалыг дэмжсэн гол шалтгаануудын нэг байв.

ТАВДУГААР САРД ИНФЛЯЦ БУУРЧЭЭ

Мягмар гарагт хөдөлмөрийн статистикийн хорооноос (BLS) дөрөвдүгээр сарын инфляцийн үзүүлэлтийг зарлалаа. Тус тайланд дурдсанаар, дөрөвдүгээр сарын хэрэглээний үнийн индекс (CPI) жилийн үзүүлэлтээр 2.3%-иар өссөн нь таамагласан 2.4%-иас доогуур, 2021 оноос хойших хамгийн удаан өсөлт болжээ. Сарын дүнгээр, нийт болон үндсэн (хүнс, эрчим хүчийг хассан) CPI аль аль нь 0.2%-иар нэмэгдсэн нь мөн таамагласан 0.3%-иас бага байв.

Мөн хөдөлмөрийн статистикийн хорооноос дөрөвдүгээр сарын үйлдвэрлэгчийн үнийн индекс (PPI)-ийг пүрэв гарагт танилцуулсан бөгөөд энэхүү үзүүлэлт гуравдугаар сараас 0.5%-иар буурч 0.2% болжээ. Тухайн уналтын ихэнх хэсгийг ашиг буурсан компаниуд бүрдүүлсэн нь зарим тарифын өсөлтийг дотооддоо шингээж буйг илтгэж байна.

ХУДАЛДААНЫ ӨСӨЛТ УДААШИРЧ, ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛ СУЛРАВ

АНУ-ын хүн амын тооллогын товчооны мэдээлснээр, дөрөвдүгээр сарын жижиглэн худалдааны өсөлт ердөө 0.1% байсан нь гуравдугаар сарын 1.7%-ийн өсөлтөөс эрс бага үзүүлэлт боллоо. Энэ нь автомашин, спортын бараа, хувцас зэрэг гуравдугаар сард огцом өсөлттэй байсан бараануудад худалдан авалт буурсныг илтгэж байгаа бөгөөд хэрэглэгчид өндөр тариф ногдуулахын өмнө хэт их худалдан авалт хийж, одоогийн түвшинд худалдан чадвар бага зэрэг суларсан үзэгдэл байж болох юм.

Баасан гарагт Мичиганы их сургуулийн хэрэглэгчийн итгэлийн индексийн урьдчилсан тайлан гарсан бөгөөд энэхүү үзүүлэлт тав дахь сардаа дараалан буурч 50.8 нэгж болжээ. Энэн нь дөрөвдүгээр сарын 52.2 нэгжээс доогуур үзүүлэлт юм. Судалгааны багийн дарга Жоанн Хсу хэлэхдээ: “Тарифын асуудал нь хэрэглэгчдийн бараг 75%-д анхаарал татсан сэдэв болж, дөрөвдүгээр сарын 60%-тай харьцуулахад мэдэгдэхүйц өссөн. Худалдааны бодлогын тодорхойгүй байдал нь эдийн засгийн талаарх хандлагад гол сөрөг нөлөө үзүүлсээр байна” гэжээ.



Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2025.05.12 – 05.18

БНХАУ-ЫН ЗАХ ЗЭЭЛ ӨСӨЛТТЭЙ БАЙНА.

АНУ-ын тарифын зөрчил буурсан тухай мэдээллийн дараа эх газрын Хятадын хөрөнгийн зах зээл долоо хоногийн түрш өсөлт үзүүллээ. FactSet-ийн мэдээлснээр, дотоодын голлох индекс болох CSI 300 индекс 1.12%-иар, Шанхайн бүртгэлийн Shanghai Composite индекс 0.76%-иар өссөн бол Хонгконгийн Hang Seng индекс 2.09%-иар нэмэгджээ.

Хятадын хувьцаанууд долоо хоногийн эхэнд хүчтэй өссөн нь өнгөрсөн амралтын өдрүүдэд АНУ-тай хийсэн тарифын хэлэлцээний үр дүнтэй холбоотой байв. Талууд харилцан бараандаа ногдуулж буй тарифуудыг түр хугацаанд бууруулахаар тохиролцсон. Энэхүү хэлэлцээр нь Бээжингийн гол шаардлагуудыг бараг бүгдийг нь хангасан гэж үзэж байна. Гэсэн хэдий ч лхагва гарагаас эхлэн хувьцааны өсөлт саарч эхэлсэн нь илүү таатай тарифын орчин бий болсноор Бээжингээс эдийн засгийн томоохон дэмжлэг үзүүлэх хүлээлт буурсан явдалтай холбоотой байв.

Сүүлийн хэдэн долоо хоногт АНУ-тай худалдааны хурцадмал байдал улам гүнзгийрэх нь БНХАУ-ын Засгийн газрыг эдийн засгаа дэмжих хүчтэй арга хэмжээнүүд авахад хүргэнэ гэсэн хүлээлт Хятадын хөрөнгийн зах зээлийг өсгөж байв. Энэ хүрээнд тавдугаар сарын эхээр БНХАУ-ын Төв банк (People's Bank of China) банкуудын заавал байлгах нөөцийн нормативыг 0.5 нэгжээр бууруулж, долоо хоногийн хугацаатай эргэн худалдан авах (reverse repo) хүүг 10 нэгжээр багасган 1.4% болгосон нь олон нийтийг гайхшруулсан алхам байв. Гэвч одоогоор АНУ-Хятадын хэлэлцээ гурван сарын хугацаанд үргэлжлэх болсонтой холбогдуулан Засгийн газраас ирэх боломжит дэмжлэгүүдийн талаарх хүлээлт түр хугацаанд саармагжиж байна.

Golomt_Capital published on TradingView.com, May 18, 2025 23:36 UTC-4

Hang Seng Index Futures · 1W · HKEX O23,264 H23,305 L22,995 C23,147 -118 (-0.51%) -118 (-0.51%)



Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open
 ZIM	 Trip.com	 HDL	 paloalto	 TGT	 snowflake	 BJ's	 DECKERS — BRANDS —	 BAH
 GILAT	 8x8	 pony	 Toll Brothers	 Baidu	 zoom	 ANALOG DEVICES	 AUTODESK	 MINI
 compugen	 agilysys	 bilibili	 tuya	 TJX	 amsc	 Advanced Auto Parts	 intuit	 MINI SOU
 OXLC	 SAFEBULKERS	 VIKING	 MODINE	 VF CORPORATION	 URBN	 lightspeed	 ROSS DRESS FOR LESS	
 QSL	 TRANSCAT	 Canaan	 KEYSIGHT TECHNOLOGIES	 WIX	 DOMO	 AT&T	 workday	
 GLOBAL SHIP LEASE	 GFIN	 AMER SPORTS	 SKYLINE CHAMPION	 Medtronic	 BBVA	 CSW INDUSTRIALS	 Copart	
 ICL	 CIFI	 万物新生	 XP Inc.	 Full Truck Alliance	 EnerSys	 RALPH LAUREN	 SILVERCORP METALS INC.	
 CB	 唯品会	 EARN	 KNOT	 LiveRamp	 RAMP	 TD Bank	 STEPSTONE	
 TH	 H	 VIASAT	 LOWE'S	 ClearSign	 CLIR	 WILLIAMS-SONOMA	 LIONGATE	
 RYANAIR	 GDS	 AUNA	 DYCOM					
	 GDS							

<http://eps.sh/cai>

© 2025 Earnings Whysers